



Gobi Financial Group JSC

“ГОВЬ ФАЙНЭНШЛ ГРУПП” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 он 1 сар 21 өдөр

Дугаар: 17/02/01

Улаанбаатар хот

ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2017 оны 04 сарын 21-ний өдрийн тооллогын комиссын -р тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

17/01/02

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2017 онд хэрэгжүүлэхээр танилцуулсан төсөл, төлөвлөгөөг батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОНОН



Gobi Financial Group JSC

“ГОВЬ ФАЙНЭНШЛ ГРУПП” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 он 4 сар 21 өдөр

Дугаар: 17/02/02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2017 оны 4-р сарын 21 –ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

17/01/02

1. Компанийн хувьцааны төвлөрлийг сааруулах, хөрөнгө оруулалт татах зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50 000 000 /тавин сая/ ширхэг хүртлэх энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Монголын Хөрөнгийн Бирж ХК болон Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Компани оноосон нэрээ цаашид явуулах үйл ажиллагааныхаа чиглэлтэй уялдуулан “Силк нэт” ХК болгон өөрчлөхийг зөвшөөрч компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлсүгэй.
3. Компаний оноосон нэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан үйл ажиллагааны чиглэлд бизнес, стратегийн зөвлөгөө, санхүүгийн зөвлөгөө, хүний нөөцийн зөвлөгөө зэрэг зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл шаардагдахгүй чиглэлүүдийг нэмж холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлсүгэй.
4. Компанийн хувьцаа болон компанийн дүрмийг бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОНОН



Gobi Financial Group JSC

“ГОВЬ ФАЙНЭНШЛ ГРУПП” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 он 4 сар 21 өдөр

Дугаар: 17/02/03

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйл, 62-р зүйлийн 62.1.3. дах заалт, 2017 оны 4-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

17/01/02

1. Компанийн хувьцааны төвлөрлийг сааруулах, хөрөнгө оруулалт татан үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50 000 000 /тавин сая/ ширхэг хүртлэх энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. 50 000 000 /тавин сая/ ширхэг хүртлэх энгийн хувьцааг нэмж гаргах шийдвэрийг “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК болон Санхүүгийн Зохицуулах Хороо зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажилласугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОНОН



Gobi Financial Group JSC

“ГОВЬ ФАЙНЭНШЛ ГРУПП” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 он 4 сар 21 өдөр

Дугаар: 17/02/04

Улаанбаатар хот

ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.8 дугаар зүйл, 2017 оны 4-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:** 17/01/02

1. Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу компанийн нэмж гаргах гэж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхээр шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОНОН



Gobi Financial Group JSC

“ГОВЬ ФАЙНЭНШЛ ГРУПП” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 он 4 сар 21 өдөр

Дугаар: 17/02/05

Улаанбаатар хот

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүд 2017 оны 04-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:** 17/01/02

1. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож амжаагүй эсвэл хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх нь эрх зүйн үр дагавар үүссэх үед үүснэ гэдгийг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хууль тогтоомжийн дагуу хувьцаа эргүүлэн авах журмыг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөл энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажилласугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОНОН



Gobi Financial Group JSC

“ГОВЬ ФАЙНЭНШЛ ГРУПП” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 он 4 сар 21 өдөр

Дугаар: 17/02/06

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2017 оны 04-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

17/01/02

1. Тус компанийн үйл ажиллагаа өнгөрсөн санхүүгийн жилд хөрөнгө оруулалтаас шалтгаалан тогтвортой биш байсан тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн болохыг хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОНОН